



## ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

**Н**ээлттэй Нийгэм Форумаас «Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль»-ийн төслийн хэлэлцүүлгийг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор 2014 оны 11 дүгээр сард зохион байгуулаа. Хуулийн төсөлд өгсөн санал, шүүмжийг боловсруулахдаа НҮБ-ын хүний эрхийн гэрээ конвенц, жишиг стандарт, хүний эрхийн механизмуудаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг анхааран судалсан. Мөн Эрүүгийн хэргэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай загвар хууль, бусад улс орны хууль тогтоомжийг харьцуулан үзлээ. Хэлэлцүүлгийн явцад гафсан санал, шүүмжийг нэгтгэн танилуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт хуулийн их дээд сургууль, судлаачдаас Н.Жинжиймаа, Д.Насанбат (МУИС-ийн Хууль зүйн ухааны сургууль), Н.Туяа (МУИС-ийн Хууль зүйн сургууль), Т.Оюунчимэг (судлаач, доктор), төрийн бус байгууллагаас Г.Баярмаа (Монголын Чөлөөт Нийгмийн Ажилтны төв), Г.Ганбаясгах (Хүйсийн тэгш эрхийн төв), А.Гэрэл-Ундрям, Г.Даваабал (Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо), К.Жанибек (Хөгжлийн хэлхээ), Д.Мөнхнаасан (Залуус эрүүл мэнд төв), Н.Нафандицээг (Монголын байгаль эхийн аврал сан), Б.Нямбаяр (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), А.Оюунчимэг (Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан), Д.Сафантуяа (Татварт иргэний хяналт), Ч.Сэмжидмаа (Сэтгэл зүйн мэдрэмж), Г.Төмөрмөнх (Ногоон соёл иргэншил хөгжил сан), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), С.Цэндбаатар (Үндсэн уртлаг), Б.Энхсайхан, Д.Энхцэцэг (Хотын захын гэр хороолол хөгжил сан) болон Б.Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) наф оролцлоо.

### Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

- Хэлэлцүүлэгт оролцогчид таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад баримтлах үндсэн зарчмуудыг хуулийн төсөлд тусгайлан зааж оруулаагүйд шүүмжлэлтэй хандаж байна. Зарчим нь тухайн хуулийн хэрэгжилтийг үнэлэх гол шалгуур болохын зэрэгцээ оролцогч талуудын эрхийн баталгаа болдог.
- Хуулийн төсөлд тусгасан цагдан хорих нөхцөл, журам нь одоогийн мөрдөгдэж байгаа Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль /СЯБЦХШБтХ/-ийн зарим зохицуулалтыг дордуулжээ.
- Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцдаа хууль сахиулах байгууллага хоорондын уялдаа холбоог тодорхойлж тусгаагүй байна. Тухайлбал, улсын хилээр нэвтрэх эрхийг нь хязгаарлахдаа хилийн хяналтын албанд мэдэгдэх тухай заасан ч эрх хязгаарлах арга хэмжээг цуцалсан талаар мэдэгдэх үүргийг орхигдуулсан.
- Тус хуулийн төсөлд тусгасан яллагдагчийн эдлэх эрх нь Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах НҮБ-ын зарчмуудад бүрэн дүүрэн нийцээгүй байна. Цагдан хоригдож байгаа хүний эрх зүйн байдлыг тогтоохдоо ялтны эрх зүйн байдалтай адилтган авч үзсэн нь олон улсын хэм хэмжээнд нийцэхгүй байна.

- Нэр томъёоны тайлбарт зайлшгүй тайлбарлавал зохих нэр томъёог тайлбараагүйгээс хуулийг хэрэглэхэд эргэлзээ төрүүлэх, субъектив байдлаар хандах нөхцлийг бүрдүүлжээ. Тайлбар хийсэн зарим нэр томъёоны агуулга, найруулгыг эргэж харах нь зүйтэй байна.
- Тус хуулийн зарим зүйл, заалт нь уг хуулиар зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна. Тухайлбал, 6.5, 6.6, 13, 14-р зүйл, 25.
- Хуулийн төсөлд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний өмнөөс өөр хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан нь ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглох зарчимтай зөрчилдөж байна.
- Яллагдагчийг цагдан хорих байранд хүлээж авах, шилжүүлэх, цагдан хорих байрнаас орох, гарах бүрт биед нь эмч, эмнэлгийн ажилтан үзлэг хийж, энэ тухай тэмдэглэлд тусган баримтжуулах тухай нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төсөлд тодорхой тусгах шаардлагатай байна. Энэ нь эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чухал зохицуулалт билээ.
- Нэг агуулга бүхий ойлголтыг хуульд өөр өөрөөр томъёолсон нийтлэг зөрчил байна. Тухайлбал, «байр», «цагдан хорих байр», «хорих байр» гэж, «дуу, дүрсний хяналтын төхөөрөмж», «дүрс бичлэгийн төхөөрөмж» гэх мэт.

## Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Зүйл, заалт		Санал, дүгнэлт	Үндэслэл
1	2.1.2	Юунд, хэрхэн хяналт тавихыг тодорхой болгох	Тайлбар нь тодорхой бус
2	2.1.4	«Эмнэлэгийн», «Хэрэгсэлийн», «Бүрдэлийг» гэснээс «Э» эгшгийг гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
3	2.1.6	«Дагаварыг» гэснийг «Дагаврын» болгох	Дугаарлалтын алдааг засах
4	2.1.7	«Нэлөөллийн арга хэмжээ»-г нэр томъёоны тайлбарт оруулах	
5	2.1.8	«Нөхөдөөс» Ө-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
6	2.1.9	«Яллагдагчийн наад захын хэрэгцээ» гэснийг «Яллагдагчийн наад захын хэрэгцээний эд зүйл» гэж өөрчлөх саналтай	Нэрлэсэн зүйлс нь эд зүйл бөгөөд материаллаг бус хэрэгцээг тусгаагүй тул
7	3.4	«...яллагдагчийн өмнөөс барьцаа өгсөн бусад хүн, хуулийн этгээд хариуцна» гэснийг хасах	Бусад хүнд нялзаахгүй байх зарчмын үүднээс
8	3.5	«Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.7-д заасан эрх хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээг авсан шүүхийн шийдвэрт...» гэж өмнөх хэсгийг өөрчлөх	Хуулиудын уялдаа холбоог гаргах, уг хэмнэх зарчмын үүднээс
9	4.2	«Гэрийн хорио» таслан сэргийлэх арга хэмжээ /TCAX/, «Эрх хязгаарлах» TCAX-г тус тусд нь зүйлчлэх. Гарах зардлын тухайд «Гэрийн хорио» TCAX-ний зардлаа яллагдагч хариуцаар тусгах	«Гэрийн хорио» TCAX нь яллагдагч өөрөө сонгох боломжтой, гэтэл «Эрх хязгаарлах» TCAX нь сонголт биш тул зардлын тухайд өөрөө хариуцах нь зарчмын хувьд буруу.
10		«Хууль сахиулах байгууллагын биечилсэн болон техникийн хяналтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ» гэснийг хасах	«Гэрийн хорио»-нд байгаа хүнд зарцуулах зардлыг төрөөс гаргах нь зохимжгүй. Энэ нь иргэдийг алдар хүнд, эд хөрөнгө, нийгмийн байдлаар ялгаварласан заалт болж болзошгүй.
11	4.4	Зүйлийн дугаар алдаатай, энэ заалт байх шаардлагагүй.	Эрх хязгаарлах арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэх тул
12	5.1.1	Хасах	Шаардлагагүй

13	5.1.2	авагдан гэснийг «авагдсан» гэж солих	
14	5.1.3	Хасах	3.4-өөс хүн, хуулийн этгээд хасах саналтай тул
15	5.2	«цахим сүлжээ» гэснийг «нэгдсэн сан» хэмээн өөрчлөх	
16	2-р хэсэг	Хэсгийн нэрэнд «сэргийлэх» гэсэн үгийг орхигдуулсан.	
17	6-р зүйл	«Цагдан хорих байгууллага» уу «цагдан хорих байр» уу нэг мөр томъёолох	
18	6.1	...аймагт байр... гэснийг оновчтой үгээр солих	«Байр» гэсэн нь нийтлэг нэр үг тул, оноосон нэр болохгүй.
19	6.2	Засгийн газрын тухай хуулийн холбогдох заалтыг ишлэх	
20	6.4	«Шашны зан үйл, мөргөл хийх» өрөөтэй байхыг нэмж тусгах, «нөхцөлийг» гэсэн үгээс ө-г хасах	
21	6.5, 6.6	Хасах	Холбогдох хуулиудаар зохицуулагдаж байгаа тул энд тусгах нь илүүц
22	7.1	6.4-тэй уялдуулах	
23	7.2	Хэт ерөнхий заасан.	СЯБЦХШБтХуулийн 13.1-т илүү тодорхой заасан.
24	7.3	Тус хуулийн 2.1.9-д наад захын хэрэгцээг эд зүйлс байхаар томъёолсон тул зөрчилдөж байна.	
25	7.4	Хууль сахиулагчийн аюулгүй байдал өөр хуулиар зохицуулагдаг тул хасах	
26	7.5	Найруулгын алдаатай тул засах	
27	9.1	«Хуульч» гэж хэн болохыг тодруулах	
28	9.2	«энэ...» гэж өгүүлбэрийт жижиг үсгээр эхлүүлснийг засах. 9.1-т заасан этгээдийн зөвшөөрснөөр гэсэнд яллагдагч, өмгөөлөгч хоёулаа багтах эсэхийг тодруулах өмгөөлөгчийн зөвшөөрөл гэдгээр өөрчлөн найруулах	
29	9.3	Стандартын дагуу хууль зүйн туслалцааны өрөөний тоог тогтоох	
30	10.1	«энэ хуульд заасан хугацаагаар» гэсний оронд зүйл, заалтыг тусгах	
31	10.2, 10.3	Найруулгыг сайжруулах	
32	11.1	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтракх субъект нь Цагдан хорих байгууллага болох уу?	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байж болох юм.
33	11.2	Цагдан хорих байрны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцлийг ч мөн 11.1-д заасан субъектүүд хамтран батлахаар тусгах	
34	12	Зарим хэсэгт «цагдан хорих байр» гэсэн нь «цагдан хорих анги»-д тусдаа байна гэсэн үг үү? 12.3-ыг 2 удаа дугаарласан тул засах	
35	13, 14	Энэ хуулиар зохицуулах зүйл биш тул хасах	
36	15.1	Цагдан хорих байранд «эмнэлэг» байх уу? Дээр «хэсэг» гэж томъёолсон.	Субъектээр тодорхой зааж оруулах
37	15.2	«зайлшгүй шаардлагаар», «урьдчилан мэдэгдсэний дагуу» г.м нэр томъёог тодорхой зааж оруулах	
38	15.3	«лавлагаа» гэдэг үгийг «тэмдэглэл» гэж солих	
39	15.4	«мэдээллийг» гэж засах	
40	15.5	Найруулгыг сайжруулах, шалгах субъектийг зааж өгөх	
41	15.6	«буую» гэсэн холбоос оновчтой биш	
42	15.7	«шаардлагатай арга хэмжээ авна» гэснийг тодорхой болгох. Хоёр дахь өгүүлбэрээс «хэргийг» гэсэн нь давтагдсан тул хасах, мөн хариуцах субъектүүдийг нягтлах.	

43	15.8	Хүлээн авах боломжгүй үед яллагдагчийг хаана байршуулахыг тодорхой заах, нэн даруй гэснийг тодорхой хугацаа гар солих	Хэсэг хугацаанд яллагдагч хаана байх нь тодорхойгүй байна.
44	15.9	«Хориотой эд зүйлс» гэж юу болохыг тодорхой тусгаж оруулах	
45	15.11	Бичиг үсэг мэдэхгүй хүнээр хэрхэн баталгаажуулахыг орхигдуулсан.	
46	15.12	«тухайн этгээдийн» гэсний оронд түүний гэж солих, «нэн даруй» гэдэгт хугацааг тодорхой зааж оруулах. Зөвхөн танилцуулахаар заасныг тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулах гэж өөрчлөх.	
47	15.14	15.15, 15.16 гэсний дугаарын алдааг засах	
48	15.15	«Наад захын хэрэгцээ»-ний эд зүйлд тухайн хүн өөрөө хариуцах зүйл ордог тул хорих байраас олгох эд зүйлийг хуульд ялгаж томъёолох	Тухайлбал, шашны эд зүйл
49	16.1	Хүлээх өрөөнд хэдий хугацаанд байлгахыг зааж өгөх	
50	16.2	«өсвөр насны хүн», «гэмт хэрэгт удаа дараа хорих ял шийтгүүлсэн этгээд» гэдгийг тодорхой болгох	
51	16.2.5, 16.1.2, 16.2, 16.3	«Этгээд» гэдэгт нэг мөр ойлголт өгөх	Этгээд гэдгийг олон янзаар тайлбарласан.
52	17	Энэ зүйлийн дугаарлалтыг бүхэлд нь засах.	
53	18.1	«хэрэгсэлийг» гэсэн үгийн э-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
54	18.2	2.1.9-т «наад захын хэрэгцээ» гэдэгт хүнсний бүтээгдэхүүн гэж оруулсан ч энэ хэсэгт «хүнсний бүтээгдэхүүн»-ийг хориглосон нь зөрчилтэй байна.	
55	18.3	«зөвшөөрсөнөөс» гэсэн үгийн ө-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
56	19.1	«өсвөр насны яллагдагч» тодорхой заах	
57	20	Холбогдох стандартыг дурдах, килокалори заах	СЯБЦХШБтХ-ийн 23.1
58	21	12, 21-р зүйлийн «ахуйн үйлчилгээ», «нийтлэг үйлчилгээ» гэсэн нэршилийг нэг мөр томъёолох	
59	22.3	Танилцуулах хугацааг тодорхой заах	
60	23	23.3, 23.5, 23.6 гэсэн дугаар байхгүй. Тоог бичгээр бичигдсэнийг тоогоор солих	
61	23.1	Найруулгыг сайжруулах	
62	23.7	Найруулгыг сайжруулах	
63	23.10, 24.2	«нэн даруй» гэснийг тодорхой хугацаа гар солих	
64	24.3	Өмгөөлийн гэснийг «Өмгөөллийн» болгох	
65	24	Дугаарыг зөвтгөн засах 24.4, 24.5 байхгүй.	
66	24.1	«шийдвэр гаргасан» гэдгийг хасах	
67	24.6	22.10-р зүйлийг иш татсан ч энэ нь байхгүй тул холбогдох заалтыг иш татах, «шаардлагатай» гэж засах, «хоол тэжээл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэхээс сайн дураар татгалзахад харшлах өвчний жагсаалт»-ыг хэн батлахыг заах	
68	24.7	Өгүүлбэрийн эхэнд орсон «Яллагдагч» гэснийг хасах	
69	25	Энэ хуулиар зохицуулах зүйл биш тул хасах	
70	4-р бүлэг	«байдлын» гэснийг «байдлыг» болгон өөрчлөх, хэний, юуны аюулгүй байдлыг хангах гэдгийг тодорхойлох	
71	26.1	13, 14 хасагдсан тул	
72	26.2	«яллагдагч» гэсний дараа таслал тавих, үгээр бичигдсэнийг тоогоор солих	

73	27.1	«тохиолдолд» гэсний дараах таслалыг авах				
74	27.1.2	«хууль сахиулах байгууллагын хяналтанд» гэснийг хасах				
75	27.1.5	«...гишүүн» гэсний ард таслал тавих				
76	27.2	«Зохистой хэмжээнд биеийн хүч хэрэглэх» гэдгийг тодорхой заах				
77	27.3	Найруулгыг сайжруулах				
78	27.4.3	«хувцасаа» гэсэн үгийн а-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу			
79	27.4.5	Нүцгэлж хийх «нэгжлэг» гэснийг оновчтой угээр солих	Нүцгэлж хийх нэгжлэг гэдэг нь утгагүй			
80	27.4.5, 27.4.7	адил утгатай				
81	28.2	Хуулийн ишлэлийг оруулах	«Төрийн нууц агуулсан»			
82	29.2	«албан» гэж солих, «яллагдагч» гэсний дараа таслал тавих				
83	30-р зүйл	«Онцгой нөхцөл» гэдгийг тодорхойлох				
84	30.2	«Яллагдагчийн оролцоотой зохион байгуулагддаг ажиллагаа» гэдгийг тодорхойлох				
85	31.1	Хэнд гомдол гаргах нь тодорхой бус, «хүний эрхийн ажилтан»-г тодорхой болгох	Тодорхой гомдлыг хүлээн авах субъект байхгүй			
86	31.2	Хэл, сонсголын бэрхшээлтэй хүний гомдлыг дуу, дүрсний бичлэг хийж бэхжүүлэхээр зохицуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд амаар гэдэг хангалтгүй. Дохионы хэлийг оруулах			
87	31.2, 31.3	Өргөдөл, гомдлыг өмгөөлөгчид дамжуулах субъектийг тодорхой заах				
88	31.3	«өмгөөлөгч» гэж нэмэх				
89	31.6	«Шууд дамжуулсан субъект» гэж хэн болохыг тодруулах, «гомдлыг» гэснийг «гомдлын» гэж засах				
90	31	32 гэж солих				
91	33.1.5	«шашны эд зүйл»-ийг тодорхой заах	Зэвсгийн чанартай зүйл байх магадлалтай			
92	33.1.7	«Бичгийн хэрэгсэл» тодорхой байх	Цаасны хутга орох уу			
93	34.2	33.1.5 адил утгатай				
94	35.1	«гэр бүлийн гишүүн» гэсний дараа таслал тавих				
95	35.2	Өмгөөлөгчид захиа бичих эрхгүй юу? «хорих байрны албан хаагч» захидалыг хянана гэсэн нь хэт ерөнхий заалт болсон. Тодорхой субъектийг зааж, нууцыг хадгалах үүрэг хариуцлагыг тусгах				
96	37.1, 37.2	Найруулгыг сайжруулах				
97	37.1.1, 37.1.2, 37.1.3	Хэд хоногийн хугацаанд гэдгийг тодорхой зааж оруулах				
98	37.3	«нөхцөлийн» гэснийг «нөхцлийн» гэж солих				
99	40.1	«эрх олгогдсон албан тушаалтан» хэн болохыг тодорхой заах				
100	42.1	Суллагдсан хүүхдийг хүлээлгэн өгөх субъектийг тодорхойлох				
101	42.2	Бичиг баримтыг яллагдагчид хүлээлгэн өгөхөөр тодорхой тусгах				
102	43.3.4	Гэр бүлийн гишүүдийн утас, харилцаа холбооны асуудлыг хэрхэх				
103	44.2	«дагаварын» гэсэн үгийн а-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу			
104	46.3	Гэр бүлийн гишүүд зөвшөөрсөн байх тухай заалт нэмэх				
105	47.2	2 удаа дугаарласныг засах				
106	47.2	Хэтэрхий олон төрөл байна.				

107	48.2	Биечилсэн хяналт тавих субъектийг тодорхой заах	
108	48.3	Тодорхой зайд зааж өгөх	
109	48.4	«нэн даруй» гэсэнд хугацаа зааж өгөх	
110	49.1	«хэрэгсэлийг» гэсэн үгийн э-г гээх, «гэрийн хорио»-г цуцалж, «цагдан хорих» тухай хүсэлт гаргах гэж оруулах, одоо байгаа хариуцлагыг хасах	
111	50.2	«хэрэгсэлийг» гэсэн үгийн э-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
112	51.1	«бусад хүн, хуулийн этгээд» гэснийг хасах, «мөнгөн тэмдэгтийн хэлбэр, шинж» гэдгийг тогтсон хэллэгээр солих	
113	51.2	54.2 гэж засах	
114	51.4	Дэлгэрэнгүй мэдээллийн агуулгад ямар ойлголт багтах	
115	51.4, 52.2, 52.4	«Шүүхийн захиргааны ажилтан» тодотгох	
116	52.2	«дагаварын» гэсэн үгийн а-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
117	52.2, 53.3	«Хувийн байдал» гэж юуг илэрхийлж байгааг тодруулах	
118	53.1, 55.3, 56.2, 58.2	«тэр даруй» гэдгийг ямар хугацаа болохыг тодруулах	
119	53.2	«биечилэн» гэсэн үгийн и-г гээх	Зөв бичгийн дүрмийн дагуу
120	54.1	Хууль сахиулах байгууллагаас хил хамгаалах байгууллагад мэдэгдэх тухай орхигдсон байгааг оруулж өгөх	Хууль сахиулах байгууллагаас Хил хамгаалах газартайгаа харилцан үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор
121	51.2	Дугаарлалтын алдааг засах, «дагаварын» гэсэн үгийн а-г гээх	
122	55.1	Албан байгууллага гэдэг үгийг хасах, «хуулийн этгээд, хүн» нь таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй субъект болох уу?	
123	56.1	Орлох бичиг баримтын талаар орхигдуулсныг оруулах	Тухайн бичиг баримт нь байхгүй бол яах вэ? цагдан хорих уу?
124	57.1	бичгээр мэдэгдэнэ гэж тусгах	
125	57.2	«...хүн, тэдгээрийн» гэснийг «хүний» гэж өөрчлөх	
126	58.1, 58.2	хуулийн этгээд, албан байгууллага гэснийг нэг мөр болгох	
127	58.2	Гурав гэснийг тоогоор илэрхийлэх	
128	58.3	Холбогдох байгууллагад мэдэгдэж ямар арга хэмжээ авахыг тодорхой заах	
129	51, 52, 53, 54, 55, 56, 57, 58	Тус зүйлүүдэд заасан ТСАХ-г цуцлах, дуусгавар болгох, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай тодорхой тусгах	

Дугаарыг эрхэлсэн: Д.ЦЭНД-АЮУШ  
 «Хууль хүний эрх» төвийн Тэргүүн

Дугаарт оролцсон: Т.ОЮУНЧИМЭГ  
 Судлаач, Доктор  
 Н.ТУЯА  
 МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик  
 сургалтын төвийн эрхлэгч  
 Б.ХИШИГСАЙХАН  
 ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
 Сүхбаатар дүүрэг,  
 Улаанбаатар - 14240  
 Монгол Улс

Утас: 976-11-313207  
 Факс: 976-11-324857  
 Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
 И-мэйл: osf@forum.mn